

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
2023 оны 09 сарын 08 өдрийн
159 албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 159068.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 146830.2 мянган төгрөгийг зарцуулж 12237.8 мянган төгрөг хэмнэсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	8-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын үр дүн	9 сард	Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 8, төлөвлөгөөт бус 3 байгууллагад нийт 11 байгууллагад хийж 287.870,8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 11141,0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.212,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар, улсын төсөвт төвлөрүүлэхээр 12.016,8 мянган төгрөг нийт 30.370,0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоож 18.971,3 мянган төгрөгийг зөрчилийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Мөн 12.224,6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 226.234,9 мянган төгрөгийн зөрчилийг

				арилгуулахаар зөвлөмж өгч ажиллалаа.. Үр дүн: Актын барагдуулалт 47,2 хувь. Нийт тогтоосон нөхөн төлбөрийн актаас 14.361,8 мянган төгрөгийн акт барагдсан, 16008.2 мянган төгрөгийн актын барагдуулах хугацаа нь болоогүй байна.
3	Сүмбэр сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	9 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 95 хувьтай үргэлжилж байна.
4	Байгууллагын 2023 оны 08 дугаар сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	9 сард	Байгууллагын 2023 оны 08 дугаар сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд 2023 оны 08 дугаар сарын 28-29-ний өдөр дотоод хяналтын багийн бүрэлдэхүүн Г.Насанжаргал, Т.Отгонтамир, Э.Цэлмэгбаяр нар хийж гүйцэтгэсэн. Дотоод хяналт шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган хугацаатай үүрэг өгч үүргийн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.
5	Талын Илч ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	9 сард	Талын Илч ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудитор хийгдэж байна. Шалгалтын явц 50 хувьтай үргэлжилж байна.
6	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ОНХСангийн 2022-2023 оны санхүүгийн	Санхүүгийн сахилга бат сайжирна	9 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.09 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж

	үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх			байна. Шалгалт 30 хувьтай үргэлжилж байна.
7	Боржигин чуулгын 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	9 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Дуу бүжгийн Боржигин чуулгын 2022-2023.07 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Шалгалтын явц 95 хувьтай байна.
8	Аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	9 сард	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 70 хувьтай.
9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	9 сард	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 8 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 95.4 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 2.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
10	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	9 сард	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 23 мэдээ байршуулсан. Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд мэдээлсэн.
11	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.		Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 5 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.

			9 сард	2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр СУГ-ын мэргэжилтэн Лхавгамаа байгууллагын албан хаагчдад угийн бичиг хөтлөх сургалтыг хийж албан хаагчид угийн бичиг хөтөлж сурлаа.
				2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр дотоод аудитор Л.Эрдэнэчимэг “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль” сэдвээр нийт албан хаагчид дотоод сургалт зохион байгууллаа. Сургалтын үр дүнд эрүүл мэндийн даатгал төлсөнөөр авч болох эрүүл мэндийн үйлчилгээний талаар суралцсан.
				2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр СХШУБайцаагч Э.Цэлмэгбаяр, дотоод аудитор Г.Насанжаргал нар дотоод аудитын ойлголт, анхаарах асуудлаар байгууллагын албан хаагчдад дотоод сургалт хийлээ.
				2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Монгол улсын Ерөнхий сайд болон танхимын сайдуудын Говьсүмбэр аймгийн иргэдтэй хийх уулзалтад бүх албан хаагчид бүрэн хамрагдсан.
				2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байгууллагын албан хаагчид Боржигин өв музей үзэж орон нутгийн соёлын өвтэй танилцлаа.
				2023 оны 09 дугаар сарын 07-ны өдөр дотоод аудитор т.Отгонтамир "Албан хэрэг хөтлөлт, стандартын тухай" сэдвээр сургалт зохион байгуулав. Үр дүнд: Албан хэрэг хөтлөлтийн стандарт мөрдөгдөнө.

				Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сум дундын Ойн ангийн зурвас газарт хувиарлагдсан 2014 оны талбайд мод арчилгаа, усалгааг IX/4, IX/18-ны хуваарьт өдрүүд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. Мод бүрийн тогоог дахин засаж, тогоолж, усалгааны үйл ажиллагааны бэлтгэл хангасан. 2. Орчны хог хаягдлыг цэвэрлэж хогийг хогийг цэгт хаясан..
--	--	--	--	---

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг

